



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ 1995 ОНООС ӨМНӨ ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР ТОГТООЛГОСОН ИРГЭНД НЭГ УДААГИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ОЛГОХ ТУХАЙ 2007 оны 11 сарын 30 өдөр Төрийн ордон, Улаанбаатар хот Дугаар 88 Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: 1.1995 оноос өмнө цэргийн албан хаагчийн тэтгэвэр тогтоолгосон иргэнд нэг сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгох ажлыг 2008 онд багтаан зохион байгуулахыг Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН